



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2019 оны 10 сарын 29 өдөр

Дугаар 419

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө худалдан авах автомашины
үнийн дээд хязгаарыг тогтоох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 24 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 3.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Гаалийн ерөнхий газрын албан ажлын хэрэгцээнд зориулан 1 ширхэг том оврын автобусыг 170,000,000.00 (нэг зуун далан сая) төгрөгт багтаан худалдан авахыг зөвшөөрч, худалдан авах автомашины техникийн үзүүлэлт, үнийн дээд хязгаарыг хавсралтаар тогтоосугай.

2. Гаалийн ерөнхий газрын дарга Б.Асралтад дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгө худалдан авах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг нягтлан бодох бүртгэл, тайланд холбогдох хууль тогтоомжийн дагуу тусгах, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Энэ тогтоолын биелэлтийг 2019 оны 4 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА

З.МЭНДСАЙХАН

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

А.АРИУНБОЛД



0000838

Төрийн өмчийн бодлого,
зохицуулалтын газрын 2019 оны 10
дугаар сарын 29-ны өдрийн
419 дугаар тогтоолын хавсралт

Гаалийн ерөнхий газар үндсэн хөрөнгө бэлтгэх зөвшөөрөл олгох

Д/д	Хөрөнгийн нэр	хэмжих нэгж	тоо шир хэг	Анхны өртөг (төгрөгөөр)	Нийт үнэ (төгрөгөөр)
1	Том оврын автобус хөдөлгүүрийн багтаамж 3900 cc	ш	1	170,000,000.00	170,000,000.00
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН			1 (нэг)	170,000,000.00 (нэг зуун далан сая)	